



УДИРДАГЫН
АКАДЕМИ

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР 2021 ОНД ХИЙСЭН АЖИЛ

...

Сургалт

Сургалтын сэдэв	Сургалтын зорилго, зорилтот бүлэг
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ЖЕНДЭРИЙН ЦАХИМ МОДУЛЬ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР	<p><i>Зорилго:</i> Жендэрийн тэгш байдлыг хангах цогц стратегийн дагуу төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах чиг үүргийг илүү жендэрийн мэдрэмжтэй болгох, шинэ нөхцөл байдалд жендэрийн хүчин зүйлийг харгалзах, оролцоо, хамтын ажиллагааг дэмжих арга барил, манлайллыг хөгжүүлэх.</p> <p><i>Зорилтот бүлэг:</i> төрийн улс төрийн алба, төрийн захиргааны алба, төрийн тусгай алба, төрийн үйлчилгээний албанд ажиллаж буй, ТА-ны хуулийн 10.2-т дурдсан удирдах албан тушаалтнууд</p>
АХИСАН ТҮВШНИЙ ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ЦАХИМ СУРГАЛТ	<p><i>Сургалтын төгсгөлд:</i> Төрийн бодлого, үйл ажиллагаа, төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн дүн шинжилгээ хийх мэдлэг ойлголттой болно.</p> <p><i>Зорилтот бүлэг:</i> Төрийн албан хаагчид</p>

Судалгаа

Магистр, докторын судалгааны чиглэлд Жендэрийн асуудлыг багтаах зорилго тавин ажиллаж байна.

Хичээлийн жил: 2021-2022

Судалгаа: Магистрын судалгааны ажил

Сэдэв: ”Төрийн албан хаагчдын жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, чадварт хийсэн шинжилгээ”
Удирдагч: Н.Болд (*Жендерийн клубын гишүүн*)

Зөвлөх үйлчилгээ

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийж буй ажлуудад асуудлыг Жендерийн мэдрэмжтэйгээр харах, “орхигдуулахгүй байх” боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.



Цахим сургалт: "Ахисан түвшний жендерийн дүн шинжилгээ"

Хэнд: УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсийн ажилтнууд

Академийн түшиц бааз болох байгууллага

Б. Багш ажилтнуудад

АХИСАН ТҮВШНИЙ ЖЕНДЕРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цахим сургалт

Оролцогч	Тоо	Хувь
Багш, ажилтан	18	45%
Үүнээс: эм	14	78%
эр	4	22%
Суралцагч	22	55%
Нийт	60	100.0%

ТӨРИЙН БОДЛОГО, ТӨСӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЖЕНДЭРИЙГ ТУСГАХ НЬ

*ЗГХЭГ, Яамд, Удирдлагын академийн удирдах
түвшиний албан хаагчдад зориулсан сургалт*

Цаг: 09:10-11:30

Огноо: 2021 оны 11-р сарын 11

Багш: Мишел Филион, MERIT төслийн зөвлөх

Сургалтын зорилго: Төрийн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд жендерийн дүн шинжилгээ, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт хийхийн ач холбогдлын талаар мэдлэг, ойлголтоо бататгах



ТӨРИЙН БОДЛОГО, ТӨСӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЖЕНДЭРИЙГ ТУСГАХ НЬ

Удирдлагын академийн багш нар зориулсан сургалт

Цаг: 09:00-12:20

Огноо: 2021 оны 11-р сарын 18

Багш: Мишел Филион, MERIT төслийн зөвлөх

Сургалтын зорилго: Төрийн албан хаагчдад зориулсан сургалтын агуулгад “Төрийн бодлого, төсөвлөлт, үйл ажиллагааг жендерийн мэдрэмжтэй болгох” тухай ойлголтыг тусгахад дэмжлэг үзүүлэх



В. Бусад

- УА-ийн захирал Д.Сүрэнчимэг ЖҮХ-ний гишүүнээр ажилладаг, цаашид академийн суралцагчид, багш, ажилтнуудын жендэрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх төлөвлөгөөтэй байгаа.
- Жендэрийн клубын сар бүрийн уулзалтад 1-3 хүн тогтмол хамрагдаж, идэвхтэй оролцож ирсэн.
- ЖМТ-ийг Дорнод аймагт нэвтрүүлэх туршилтын төсөлд багш Л.Отгонтуяа үндэсний зөвлөхөөр ажилласан.
- Туршилтын төслийн тайланг танилцуулах уулзалтад ТАС-ийн захирал Д.Байгал, МДИ-ийн захирал Амарбаясгалан нар оролцож цаашид ТАХ-дыг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлээр хэрэгжүүлэх ажлын талаар ярилцсан.
- Багш нар ТАХ-дад зориулсан сургалтын агуулгадаа жендэрийн асуудлыг (практик хэрэгцээнд тулгуурлан) тусгах ажлыг эхлүүлээд байна.

- Бага насны хүүхэдтэй эмэгтэй багш, суралцагчдад зориулан “Эх, хүүхдийн өрөө” байгуулах ажлыг SYLFF-ийн тэтгэлэгтэйгээр суралцаж буй магистрантууд санаачилан Академийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлж байгуулсан.

